



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 13 өдөр

Дугаар А/332

Хэрлэн сум

Үйл ажиллагаанд хөрөнгө
зарцуулах тухай.


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дотоод, гадаад хамтын ажиллагааны хүрээнд аймаг, орон нутгаа сурталчлан таниулах үйл ажиллагааны зардалд зориулж 4,070,000 (дөрвөн сая далан мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн урьдчилан төлөвлөх боломжгүй нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас олгохыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Гантулга)-д гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023
оны 06 дугаар сарын 13-ны
..... дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

Хөрөнгө зарцуулалтын тооцоо

№	Зардлын нэр	Нийт дүн
1	Материалийн үнэ	4.070.000
	Дүн	4.070.000